



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/24

Мөрөн

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-гийн "а", Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.7, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 14 дүгээр зүйлийн 14.7; аймгийн ИТХ-ын 2014 оны 08 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох (1) аж ахуйн нэгжийн нэр, талбайн хэмжээ, байршил, солбилцол, тусгай зөвшөөрлийн хугацааг хавсралт ёсоор баталсугай.


2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Л.Лхагвасүрэн/, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Р.Жаргалсайхан/, Бүрэнтогтох сумын Засаг дарга /Г.Сонинпил/ нарт даалгасугай.

3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбайг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга /Н.Бямбадорж/ нарт даалгасугай.

4. Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг аймаг орон нутгийн орлогод төвлөрүүлж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн /Г.Энхбаяр/-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэн /Х.Ган-Очир/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД

